



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/247

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 4.2.4, 4.1.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн прокурорын газарт үйл ажиллагааны дэмжлэг 15,000,000 (арван таван сая), Хархорин сум дахь сум дундын прокурорын газарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хэрэгжүүлэх зардалд 7,500,000 (долоон сая таван зуу мянга), Арвайхээр сумын 3 дугаар багийн төвийн барилгын засварын зардалд 35,000,000 (гучин таван сая), Боловсрол, соёл, урлагийн газрын авто машины засварын зардал 2,500,000 (хоёр сая таван зуун мянга), Уянга сумын ахмадын байрны дээврийн засварын зардал 9,000,000 (есөн сая), Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Камержуулалт-1” аяны зардалд 11,220,000 (арван нэгэн сая хоёр зуун хорин мянга), Зэвсэгт хүчний 256 дугаар ангид явуулын пост худалдан авах зардалд 4,500,000 (дөрвөн сая таван зуу мянга), Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд дэмжлэг 15,000,000 (арван таван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардалд нийт 99,720,000 (ерэн есөн сая долоон зуун хорин мянга) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100541